

Эрүүл мэндийн яам эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулан англи хэлний болон гадаад сургалтыг зохион байгуулж байна. 2012 оны эхний улиралд зохион байгуулагдах сургалтанд сонгогдсон байгууллагуудаас эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн материалыг хүлээн авч байна. Тухайн онд батлагдсан чиглэлээр гадаад сургалтанд хамрагдах мэргэжилтнүүдэд тавигдах шаардлагыг хангасан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өөсрдийн намтраа загвар ([НАМТРЫН ЗАГВАР ТАТАЖ АВАХ](#))-ын дагуу бөглөж tsatsral@moh.mn, gantuya@moh.mn, erdenetuya@moh.mn, e-mail хаягуудаар илгээнэ үү. Ирүүлсэн материалууд гадаадад сургалтанд хамрагдахыг хүссэн мэргэжилтнүүдийн мэдээллийн санд орох ба эхний сонгон шалгаруулалтанд тэнцвэл таныг ярилцлаганд дуудах болно.

Гадаад сургалтанд хамрагдах эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага:

- Сонгогдсон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа
- Сонгон шалгаруулалтанд оролцогч нь 2011 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 45 ба түүнээс доош настай байх;
- Сургалтын батлагдсан чиглэлийн дагуу мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Сонгосон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд гадаадын сургалтанд хамрагдах тохиолдолд сургалтын дараа уг чиглэлээрээ төрийн өмчийн эмнэлгийн байгууллагад суралцсан чиглэлээрээ 5-аас доошгүй жил ажиллахаар гэрээ байгуулж ажиллахыг зөвшөөрч баталгаажуулсан байх;
- Тухайн сургалтанд мэргэжил, эрхэлж буй албан тушаал нь тохирсон байх
- Гадаадын сургалтанд хамрагдах хүсэлт гаргагч нь англи хэлний дундаас доошгүй түвшний мэдлэгтэй байх зэрэг болно.

2012 оны эхний улиралд зохион байгуулагдах гадаад сургалт:

- Эмнэл зүйн дархлаа судлал (ЭХЭМҮТ, УКТЭ, КНИИЭ, ШТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, АӨСТ, Геронтологийн төв, БОЭТ-үүд, АНЭ-үүд, ДНЭ-үүд)
- Дүрс оношлогоо (СТ, MRI) (ЭХЭМҮТ, УКТЭ, КНИИЭ, ШТЭ, ХӨСҮТ, ХСҮТ)
- Хүүхдийн дурангийн оношлогоо, эмчилгээ (ЭХЭМҮТ, УКТЭ, КНИИЭ, ШТЭ, ХӨСҮТ, ХСҮТ)
- Хүүхдийн бөөрний дурангийн мэс засал (ЭХЭМҮТ, УКТЭ, КНИИЭ, ШТЭ, ХСҮТ)
- Хүүхдийн нөхөн сэргээх эмчилгээ (ЭХЭМҮТ, УКТЭ, КНИИЭ, ШТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, БОЭТ-үүд, АНЭ-үүд, ДНЭ-үүд)
- Хүүхдийн согог судлал (ЭХЭМҮТ, НКС, УКТЭ, КНИИЭ, ШТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, БОЭТ-үүд, АНЭ-үүд, ДНЭ-үүд)
- Хүүхдийн Сувилахуй (ЭХЭМҮТ, УКТЭ, НКС, КНИИЭ, ШТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, БОЭТ-үүд, АНЭ-үүд, ДНЭ-үүд)
- Хүүхдийн цээжний хөндийн мэс засал (ЭХЭМҮТ, УКТЭ, КНИИЭ, ШТЭ, ХӨСҮТ, ХСҮТ, БОЭТ-үүд)
- Хүүхэд, өсвөр үеийн сэтгэц судлал. (ЭХЭМҮТ, СЭМҮТ, БОЭТ-үүд, АНЭ-үүд, ДНЭ-үүд)